



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын сэдэв: Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй байна.

Аудитын код: ДГА-2019/18/НА

Цахим хуудас:
www.audit.mn

Дорноговь аймаг
2020 оны 1 сар

Дарга, Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734
Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 70523020
Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Лүндэгмаа
Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор: П.Энхбаяр
Цахим хаяг: enkhbayar.p@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	
Хүснэгтийн товъёг	
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5-6

БҮЛЭГ 1.Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа хуулийн зарим заалттай нийцээгүй бай

А.1. Орон нутгийн саналыг харгалзахгүй тусгай зөвшөөрөл олгож байгаагаас сонгон шалгаруулахаар батлагдсан зарим талбайг соёлын өвд бүртгэгдсэн болон орон нутгийн тусгай хэрэгцээний газар нутагтай давхцуулан олгосон байна.....	7-12
А.1.1 Ашигт малтмал газрын тосны газраас хайгуулын талбайн солбицлыг тодорхойлох саналыг талбайн зургийн хамт аймгийн Засаг даргад ирүүлсэн байна.	7-9
А.1.2 Зарим талбайн солбицол тодруулах саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээгүй хүргүүлсэн байна.....	9-11
А.1.3 Нэг тусгай зөвшөөрлөөр олгосон ашигт малтмалын хайгуулын талбайн хэмжээ нь хуульд заасан хэмжээнд байна.....	11
А.1.4 Тусгай зөвшөөрөл олгосон мэдээллийг орон нутгийн холбогдох байгууллагуудад ирүүлдэггүй байна.....	11
А.1.5 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 4-6 удаа сунгасан нь хуулинд заасан давтамжийг зөрчсөн байна.....	11
А.2 Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон мэдээллийг цахим сайтаас олж авсан байна.....	12
А.2.1 Ашигт малтмал, газрын тосны цахим сайтаас сар бүрийн тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээллийг авдаг байна.....	12
А.2.2 Газар ашиглах эрхээ улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.....	12
А.2.3 Аймгийн хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, сунгуулсан компани байхгүй байна.....	12

БҮЛЭГ 2. Орон нутгийн захиргаа, уул, уурхайн компаниуд үйл ажиллагаагаа төлөвлөж, бодлого зорилт дэвшүүлсэн ч ашигт малтмалын тухай хууль, журмыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Б.1 Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтын хүрээнд уул уурхайн компаниуд орон нутагт дэмжлэг, хандив тусламж үзүүлсэн байна.....	13-16
Б.1.1. Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлж зөвлөгөөн зохион байгуулсан байна.....	13-14
Б.1.2. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилт бүрэн хангагдаагүй байна.....	14
Б.2 Талуудын хамтран ажиллах гэрээний хэрэгжилт хангалтгүй байна	15
Б.2.1. Гэрээнд байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг тусгасан ч хэрэгжилт хангалтгүй байна	15
Б.2.2 Үйл ажиллагаа явуулсан компаниуд ажлын байр нэмэгдүүлж ажилласан байна.....	16-17
Б.2.3 Орон нутгийн төсөвт төлөх гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлжээ.....	17-21
Б.2.4 Уул уурхайн компаниуд эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй ажиллагааг хангах гэрээний үүргээ хангалтгүй биелүүлжээ.....	21

БҮЛЭГ 3. Хяналтаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан компаниудад ашигт малтмалын болон бусад холбогдох хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах асуудлаар үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай байна.

В.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль журмын заалтыг мөрддөггүйгээс байгаль хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.....	22
В.1.1. Холбогдох байгууллагуудын ажлын хариуцлага сул, хяналт хангалтгүй байгаагаас хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө хянуулж батлуулах, тайлагнах ажил хангалтгүй байна	22
В.1.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг бүрэн ирүүлээгүй, тайланг шаардаж аваагүй байна	23
В.2. Хяналтаар уул уурхайн компаниуд ашигт малтмалын болон холбогдох бусад хууль тогтоомж зөрчсөнийг илрүүлсэн байна.....	26-29

В.2.1 Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан мэдээ тайлан байхгүй байна.....	26
В.2.2 Ашигт малтмалын ашиглалтын зөвшөөрөл эзэмшигч компаниудад хяналт тавьж зөрчил илрүүлсэн ч хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих хяналт хангалтгүй байна.....	26-28
В.2.3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг ихэнх компаниуд ирүүлээгүй байна.....	28-29
В.3 Хамтран ажиллах гэрээг дүгнээгүй, үр дүнг тооцоогүй байна.....	29-31
В.3.1 Талууд гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.....	29-30
В.3.2 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид сумын төсвийн орлогод хогны төлбөр төлж, байгууллагуудад хандив тусламж үзүүлсэн байна.....	30-31
В.3.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс эд хөрөнгийн хохирол төлөх асуудал гараагүй байна.....	31
Холбогдох байгууллагын санал:.....	31-35
Саналд өгсөн тайлбар:.....	
ДҮГНЭЛТ:	37
ЗӨВЛӨМЖ:	38
Аудитыг гүйцэтгэсэн багийн гишүүд	39
Тайлан баталгаажуулах тухай тушаал	40

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
МУ	Монгол улс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЗ	Тусгай зөвшөөрөл
ААНБ	Аж ахуй нэгт байгууллага
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
БО	Байгаль орчин
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХБ	Мэргэжлийн хяналтын байгууллага

Хүснэгтийн товчлол

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ	
Хүснэгт 2	Орон нутгийн саналыг харгалзаагүй олгосон хайгуулын талбайн хэмжээг	
Хүснэгт 3	Уул уурхайн компаниудаас 2017-2019 онд төлсөн ХХОАТ болон тээврийн хэрэгслийн татвар төлөлт	
Хүснэгт 4	Сумдад газрын төлбөрийн ногдуулалт, төлсөн төлбөр	
Хүснэгт 5	Газрын төлбөрийн 50.0 сая төгрөгөөс дээш өртэй байгаа компаниуд	
Хүснэгт 6	Усны төлбөрийн орлогын төлөвлөгөө, орсон орлого	
Хүснэгт 7	НДШ төлөлт	
Хүснэгт 8	Сумдын газар нутгийн хэмжээ, хамрагдсан хайгуулын талбай, газарт нутагт эзлэх хувь	

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг аймгийн ИТХ-ын захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2019 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт”-д Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд хийнэ.
Аудитын зорилт	Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх; ➤ Тусгай зөвшөөрөл эзэмшигч, нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа хуульд нийцсэн эсэх; ➤ Тусгай зөвшөөрөл бүхий компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьсан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ЗДТГ, Айраг, Даланжаргалан сумдын ЗДТГ, ИТХ, МХГ, ГХБХБГ, БОАЖГ, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Айраг сумын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Мон ли да ХХК, Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Олон ихт баян ХХК, баяжуулах үйлдвэр, Эко хэлхээ ХХК зэрэг байгууллагуудын тус аудитад холбоотой 2017-2019 онуудын үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	ҮАГ-аас Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын үйл ажиллагаанд чанарын хяналт шалгалтыг 2019 оны 11 сарын 21-ний өдрөөс 10 хоног хийсэн, мөн уул уурхайн дийлэнх компаниудын үйл ажиллагаа хүйтний улиралтай холбоотой зогссон тул аудитын хамрагдах хүрээ хязгаарлагдаж, энэхүү аудитыг гүйцэтгэх хугацаа хойшилсон болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Нийцлийн аудитын түр журамд заасан арга зүйг ашиглан Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов баталсан төлөвлөгөө, хөтөлбөр, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, сүүлийн 3 жилийн байдлаарх судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Ц.Лүндэгмаа, аудитор П.Энхбаяр нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр батлуулж, талбарын ажлыг 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн дотор бичиж, 2020 оны 1 сарын 9-нд аудитын дүнгийн талаар холбогдох хүмүүстэй уулзалт ярилцлага хийлээ. Аудитын тайланг хянуулан, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2020 оны 1 дүгээр сарын 24-нд аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

.....

БҮЛЭГ 1. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа хуулийн зарим заалттай нийцэхгүй байна.

А.1 Орон нутгийн саналыг харгалзахгүй тусгай зөвшөөрөл олгож байгаагаас сонгон шалгаруулахаар батлагдсан зарим талбайг соёлын өвд бүртгэгдсэн болон орон нутгийн тусгай хэрэгцээний газар нутагтай давхцуулан олгосон байна.

А.1.1 Ашигт малтмал газрын тосны газраас хайгуулын талбайн солбицлыг тодорхойлох саналыг талбайн зургийн хамт аймгийн Засаг даргад ирүүлсэн байна.

Дорноговь аймагт 2017 онд нийт 419, 2018 онд 386, 2019 оны 10-р сарын 03-ны өдрийн статистик мэдээгээр 358 хүчин төгөлдөр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүртгэгдсэн байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, талбайн хэмжээний мэдээллийг Уул уурхайн хүнд үйлдвэрийн яам, АМГТГ-ын Эрдэс баялгийн статистик мэдээнээс иш татав.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээг Хүснэгт №1-д харуулав.

Хүчин төгөлдөр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо,
талбайн хэмжээ /2017-2019 он/

Огноо	Бүгд			Үүнээс					
				Ашиглалт			Хайгуул		
	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь
2017	419	1773.5	16.2	170	213.8	2.0	249	1559.7	14.3
2018	386	1548.3	14.2	180	218.0	2.0	206	1330.2	12.2
2019	358	1344.7	12.5	185	228.5	2.1	173	1116.2	10.2

Ашигт малтмалын тухай хуулийн 17.1-т “...төрийн захиргааны байгууллага нь талбайн солбицлыг тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд талбайн зургийг хавсаргана” гэж заасан.

АМГТГ хуулийн дагуу, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд хайгуул явагдах аймгийн Засаг даргад бичгээр мэдэгдэн, төлөвлөгдсөн талбайн зургийг ирүүлсэн байна.

Тус газраас 2017 онд 12 сумын 88.3 мянган гектар талбайн солбицлыг тодорхойлох 19 санал, 2018 онд 14 сумын 967.8 мянган гектар талбайн солбицол тодорхойлох 2 санал, 2019 онд 1 сумын 2.6 мянган гектар талбайн солбицол тодорхойлох 1 саналыг тус тус орон нутагт ирүүлжээ. АМГТГ нь тусгай зөвшөөрөл дуусгавар болж цуцлагдсан болон хаагдсан талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг холбогдох

хуулийн 11.1.23¹, 11.1.25², 17.1³, 17.4⁴, 53.6⁵ дахь заалтыг тус тус зөрчиж олгосон байна. Тухайлбал:

- Даланжаргалан сумын Худагт нэртэй 10.6 мянган гектар талбайг 2017 онд Олон ихт баян ХХК-д /XV-020816/ олгосон. Тус талбай нь "Жэн Дэ Жюн Туо Майнинг Хөгжил" ХХК-д 2015 онд олгогдоод 2017 онд хаагдсан талбай байсан байна.
- Алтанширээ сумын Унаа хад нэртэй 2.6 мянган гектар талбайг 2019 онд Утаатболор ХХК-д /XV-021368/ шууд олгосон. Тус талбай Майхан өндөр ХХК-д 2010 онд олгогдож, 2016 онд цуцлагдсан. /Тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд талбайн солбицлыг дахин тодруулж, орон нутгийн саналыг харгалзан тусгай зөвшөөрөл олгох байтал 2016 онд шууд олгосон/.

МУ-ын Засгийн газрын 2018 оны 243 дугаар тогтоолын хавсралтаар сонгон шалгаруулах ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг баталжээ. Сонгон шалгаруулахаар батлагдсан зарим талбай орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газар нутагтай давхацсан, соёлын биет өвд бүртгэгдсэн байна. Тухайлбал:

- Хатанбулаг сумын 13 байршилд 143.2 мянган гектар талбай сонгон шалгаруулахаар зарлагдсан бөгөөд сумын ИТХ-ын 2018 оны 05/324 тоот албан бичгээр орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан, бага дархан цаазат хамгаалалтын бүс болон соёлын биет өвд бүртгэгдсэн, орон нутгийн тахилгат, ховор ан амьтан бүхий нутгийн талбай зэрэг шалтгаанаар тусгай зөвшөөрөл олгох боломжгүй саналыг хүргүүлсэн ч сонгон шалгаруулалт зарласан байна.
- Хөвсгөл сумын 24 байршилд 43.5 мянган гектар талбай сонгон шалгаруулахаар зарлагдсан бөгөөд сумын Засаг даргын 2018 оны 5/111 дугаартай албан бичгээр орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутагтай давхацсан зэрэг шалтгаанаар тусгай зөвшөөрөл олгох боломжгүй саналыг хүргүүлсэн байна.

Энэ нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль⁶, Ашигт малтмалын тухай хууль⁷, Амьтны тухай хуулиудыг⁸ тус тус зөрчиж байна.

¹Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-д энэ хуулийн 12.1.5-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох.

² 11.1.25.энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах.

³17.1.Энэ хуулийн 11.1.25-д заасны дагуу төрийн захиргааны байгууллага нь талбайн солбицлыг тодорхойлохдоо тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд талбайн зургийг хавсаргана.

⁴17.4.Энэ хуулийн 17.3-т заасны дагуу Засгийн газраас баталсан талбайн солбицлын хүрээнд төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялгаж, сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

⁵53.6.Тусгай зөвшөөрөл дуусгавар болсон талбайд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.

⁶Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.3-д Соёлын өвийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулахгүйгээр тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална. 38.1.Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно: 38.1.1.түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулах; 38.1.2.палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох;

⁷Ашигт малтмалын тухай хуулийн 401.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.

⁸Амьтны тухай хуулийн 6.1.3-д амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах;

Аймгийн Засаг дарга АМГТГ-аас 2018 оны 7/616 тоот албан бичгээр ирүүлсэн мэдэгдлийн дагуу дээрх сумдын саналыг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжгүй гэсэн саналыг 2018 оны 1/412 тоот албан бичгийг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.

Иймд орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газар нутагтай давхацсан, соёлын биет өвд бүртгэгдсэн дээрх талбайнуудыг холбогдох газарт дахин хандан сонгон шалгаруулалтаас чөлөөлүүлэх нь зүйтэй байна.

А.1.2 Зарим талбайн солбицол тодруулах саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээгүй хүргүүлсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 17.2-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 17.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч, 45 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасан үндэслэлээр татгалзсан хариу өгч болно” гэж заажээ.

Аймгийн Засаг дарга хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой газар, талбай, солбицлын талаар ирүүлсэн мэдэгдлийн дагуу холбогдох шатны ИТХ-аас саналыг авч, АМГТГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

Сумдын ИТХ хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор санал болгосон талбай нь өвөлжөө, хаваржааны газар, бэлчээр уст цэг, орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутагтай давхцаж байгааг нягтлан, хуралдаанаар хэлэлцүүлж саналыг аймгийн Засаг даргад ирүүлдэг бөгөөд Засаг дарга сумдаас ирүүлсэн саналыг нэгтгэн аймгийн ИТХ-д уламжлан саналыг авч, АМГТГ-т хүргүүлэн ажилладаг байна.

Харин АМГТГ-ын 2017 оны 7/552, 7/533, 7/600, 7/611, 7/608, 7/3943, 7/3941, 7/3969, 7/6081, 7/6080, 7/6082 тоот албан бичгүүдээр ирсэн мэдэгдлийн дагуу зарим сумдаас ирүүлсэн нийт 58.9 мянган гектар талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзан саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахгүй хүргүүлсэн байна. Тухайлбал:

- Айраг сумын Цагаан нэртэй 7.0 мянган гектар талбай,
- Айраг сумын Алаг толгод нэртэй 4.9 мянган гектар талбай,
- Даланжаргалан сумын Гашуун нэртэй 6.9 мянган гектар талбай
- Даланжаргалан сумын Далан нэртэй 3.9 мянган гектар талбай
- Мандах сумын Энгэр нэртэй 9.2 мянган гектар талбай
- Хатанбулаг, Хөвсгөл сумдын Хутаг уул нэртэй 2.1 мянган гектар талбай
- Эрдэнэ сумын Бор дэл нэртэй 3.9 мянган гектар талбай
- Сайншанд, Сайхандулаан сумдын Хулсан, Өндөр жавхлан нэртэй нийт 21.0 мянган гектар талбай

Ашигт малтмалын тухай хуулийн 17.2⁹ дахь заалтыг зөрчиж, аймгийн ИТХ-аас санал аваагүй хүргүүлсэн дээрх талбайнуудаас Даланжаргалан сумын Далан нэртэй 3.9

⁹Ашигт малтмалын тухай хуулийн 17.2-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 17.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч, 45 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.

мянган гектар талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон бөгөөд хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг дэмжихгүй гэсэн орон нутгийн саналыг харгалзаагүй байна.

АМГТГ-ын 2017 оны 7/1766, 7/611, 2018 оны 7/3756, 7/3757 тоот мэдэгдлийн дагуу аймгийн Засаг дарга хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбай, солбицлын талаар холбогдох сумдад хүргүүлж, аймаг, сумын ИТХ-ын хайгуул хийхийг дэмжихгүй гэсэн саналыг 2017 оны 1/803, 2018 оны 1/1266 тоот албан бичгээр хуулийн хугацаанд АМГТГ-т хүргүүлсэн байна.

АМГТГ орон нутгийн дээрх саналыг үл харгалзан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон байна. Тухайлбал: 2017 онд тус аймгийн Алтанширээ, Даланжаргалан сумдын 51.0 мянган гектар талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл 5, 2019 онд Хатанбулаг, Хөвсгөл, Мандах, Алтанширээ сумдын нутаг дэвсгэрийг хамарсан 15.0 мянган гектар талбайд 3 хайгуулын тусгай зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Мөн 2017 онд Даланжаргалан сумын Алаг толгод нэртэй 4.9 мянган гектар талбайд, Гашуун нэртэй 6.9 мянган гектар талбайд, Залаат нэртэй 0.8 мянган гектар талбайд орон нутгийн саналыг харгалзахгүй сонгон шалгаруулалт зарлагдсан байсныг аймгийн Засаг даргын 2017 оны 1/1836 тоот албан бичгээр сонгон шалгаруулалтыг хүчингүй болгох саналыг хүргүүлж байсан боловч шийдвэрлэсэн талаар хариу ирүүлээгүй байна.

Орон нутгийн саналыг харгалзахгүйгээр 2017-2019 онд нийт 67.9 мянган гектар талбайд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгожээ. *Орон нутгийн саналыг харгалзаагүй олгосон хайгуулын талбайн хэмжээг хүснэгт №2-д харуулав.*

Орон нутгийн санал харгалзаагүй олгосон талбай

сум	Компанийн нэр	талбайн нэр	ТЗ-ийн дугаар	Талбай хэмжээ мян.га	олгосон огноо
Алтанширээ	Голден говь констракшн	Тойром	XV-021077	1.70	2007.07.30
Даланжаргалан	Арвижих Энерги	Далан	XV-020830	3.60	2017.05.30
Алтанширээ	ВУС	Тойром	XV-016853	12.80	2017.05.08
Алтанширээ, Дэлгэрэх	Френдли майнинг консалтинг	Баянтал	XV-020951	15.80	2017.10.23
Дэлгэрэх	Винд майнинг	Баянтал	XV-020865	8.30	2017.07.19
Даланжаргалан	Олон ихт баян	Худагт	XV-020816	10.6	2017.05.18
Алтанширээ	Тайжийн буян	Айраг толгой	XV-021281	1.3	2019.03.27
Мандах, Хөвсгөл, Хатанбулаг,	Ричмайнинг	Орших төхөм	XV-021299	11.2	2019.04.22
Алтанширээ	Утаатболор	Унаа хад	XV-021368	2.6	2019.07.16
Дүн				67.90	

А.1.3 Нэг тусгай зөвшөөрлөөр олгосон ашигт малтмалын хайгуулын талбайн хэмжээ нь хуульд заасан хэмжээнд байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 17.7-д Нэг тусгай зөвшөөрлөөр олгох хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 150 мянган гектараас ихгүй байна гэж заасан.

Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт нэг тусгай зөвшөөрлөөр олгосон ашигт малтмалын хайгуулын талбайн хэмжээ нь хуульд заасан дээрх хэмжээнд нийцсэн байна.

А.1.4 Тусгай зөвшөөрөл олгосон мэдээллийг орон нутгийн холбогдох байгууллагуудад ирүүлдэггүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 20.7-д “Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ” гэж заасан.

Гэвч хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан талаарх мэдээллийг аймгийн БОАЖГ болон тухайн талбай байрших аймаг, сумын Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд албан ёсоор мэдэгддэггүй бөгөөд орон нутгийн холбогдох байгууллагууд АМГТГ-ын цахим сайтаас хамаарал бүхий талбайг татаж мэдээлэл авдаг байна.

А.1.5 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 4-6 удаа сунгасан нь хуулинд заасан давтамжийг зөрчсөн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.4-д “Төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл авах, хугацааг нь сунгах, шилжүүлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хүлээлгэн өгөх, хилийн маргааныг шийдвэрлүүлэх, хайгуулын ажлын төлөвлөгөө, мэдээ, тайланг хянуулах ажиллагааны үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох бүрэн эрхтэй; 21.1.5-д “Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд цацраг идэвхит ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар 3 удаа сунгуулна” гэж заасан.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах ААНБ хайгуулын тусгай зөвшөөрлийг 4-6 удаа сунгуулсан нь дээрх хуулийн заалтыг зөрчиж байна. Тухайлбал:

- ЛАВА ХХК Хатанбулаг Өндөр хошуу нэртэй 2.6 мянган гектар талбайд XV-013828 тоот тусгай тусгай зөвшөөрлийг 2005 онд авч, 2020 оныг хүртэл 5 удаа сунгасан
- Их хүрэн толгой ХХК Сайхандулаан сумын Хөх үзүүр-1 нэртэй 7.7 мянган гектар талбайд XV-017022 тоот тусгай тусгай зөвшөөрлийг 2007 онд авч, 2022 он хүртэл 5 удаа сунгасан.
- БҮС ХХК Алтанширээ сумын Тойром нэртэй 12.8 мянган гектар талбайд XV-016853 тоот тусгай тусгай зөвшөөрлийг 2007 онд авч, 2020 он хүртэл 4 удаа сунгасан байна.
- Голден говь констракшн материалз ХХК Алтанширээ сумын Тойром нэртэй 1.7 мянган гектар талбайд XV-021077 тоот тусгай тусгай зөвшөөрлийг 2007 онд авч, 2020 он хүртэл 4 удаа сунгасан
- Туяа-Ундром ХХК Даланжаргалан сумын Далангийн гашуун нэртэй 0.9 мянган гектар талбай, Зүүн далан нэртэй 2.1 мянган гектар талбайд XV-013570 тоот тусгай зөвшөөрлийг 2008 онд авч, 2022 оныг хүртэл 4 удаа сунгасан байна.

Иймд хууль зөрчин сунгагдсан дээрх тусгай зөвшөөрлүүдийг холбогдох газарт хандан хянуулах нь зүйтэй байна.

А.2 Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон мэдээллийг цахим сайтаас олж авсан байна.

А.2.1 Ашигт малтмал, газрын тосны цахим сайтаас сар бүрийн тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээллийг авдаг байна

Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д “Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ” гэж заасан хэдий ч албан бичгээр мэдээллийг ирүүлээгүй байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын цахим сайтаас сар бүрийн тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээллийг авдаг байна.

А.2.2 Газар ашиглах эрхээ улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.12-т “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд газар ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасан байна. Улсын бүртгэлийн хэлтэс 2019 онд 20 ААН-ийн 25 тусгай зөвшөөрлийн газарт “А” дугаар 22, “Э” дугаар 3-ыг олгож улсын бүртгэлд бүртгэсэн байна. Өмнөх жилүүдэд ЭБХ-ээс зөвхөн дугаар олгодог байсан ба тухайн суманд эрхийн улсын бүртгэл хийгдсэн байна.

Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.2-т “Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох” гэж заасан байхад ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий компаниудын 811.69 га талбайн газарт захирамж шийдвэр гараагүй байна. Тухайлбал: Даланжаргалан сум дахь МАК цемент ХХК-ний Манж толгой 87.57 га газрын MV-016735 талбай, Паурлэнд ХХК-ний Арын худаг 133 га MV-009517 талбай, Штайнколе ХХК-ний Далан 345 га MV-011281 талбай, Билэгт зурвас ХХК-ний Зэст 90.12 га MV-013403 талбай, Гүн Орд ХХК-ний Баруун бурхант 156 га MV-015222 талбайд Даланжаргалан сумын Засаг даргын шийдвэр гараагүйгээс газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгоогүй байна.

Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зохих хууль тогтоомж, гэрээний дагуу газрын төлбөр төлнө” гэж заасан байна. Аймгийн хэмжээнд ашигт малтмал ашиглах аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн газраа баталгаажуулсан 117 аж ахуйн нэгж байна. Газрын төлбөрийн ногдуулалт, төлсөн төлбөрийг аудитын дүнгийн Б.2.3 дахь хэсгийн Хүснэгт № 4-т харуулав.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагаас газраа баталгаажуулсан 112 компани байгаа бөгөөд нийт ашиглалтын зөвшөөрөлтэй компанийн 39.5 хувь нь газраа баталгаажуулаагүй байна.

А.2.3 Аймгийн хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, сунгуулсан компани байхгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.7-д “Цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг ашигт малтмалын нөөцийн хэмжээнээс хамааран 20, 20 жилээр сунгуулах” гэж заасан байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу 30 жилийн хугацаагаар буюу 1995-2025 он хүртэлх хугацаатай Монголросцветмет компанид олгосон байх бөгөөд аймгийн хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, сунгуулсан компани байхгүй байна.

БҮЛЭГ 2. Орон нутгийн захиргаа, уул, уурхайн компаниуд үйл ажиллагаагаа төлөвлөж, бодлого зорилтоо дэвшүүлсэн ч ашигт малтмалын тухай хууль, журмыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Б.1 Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтын хүрээнд уул уурхайн компаниуд орон нутагт дэмжлэг, хандив тусламж үзүүлсэн байна.

Б.1.1 Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлж зөвлөгөөн зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Тэргүүлэх зорилт 1.1-т “Стратегийн ач холбогдол бүхий ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжин аймгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах бодлого баримтална”, 1.6-д “Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхийг дэмжиж, тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-тай жил бүр уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулан уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллана” гэж заасан байна.

Зорилтын биелэлтийн тайланд дараах асуудлыг бичсэн байна Үүнд:

2017 он: -Айраг суманд уул уурхайн компаниудтай уулзалт зохион байгуулсан бөгөөд уул уурхайн 48 компанитай гэрээ байгуулсан байна. Нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд Сайншанд суманд Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн төв, Даланжаргалан сумын спорт заалыг шинээр барих зэрэг бүтээн байгуулалт, мөн даамын дэлхийн аварга, боксын олон улсын тэмцээн, Япон улстай сурагч солилцоо, зорилтот бүлгийн оюутан залуус, иргэдэд дэмжлэг үзүүлэх зэрэг нийгмийн салбарт нийт 2.4 тэрбум төгрөгийн дэмжлэгийг уул уурхайн компаниудаас үзүүлж, улс, орон нутгийн төсөвт 4.4 тэрбум төгрөг, үүнээс орон нутгийн төсөвт 1.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь 2016 оны мөн үеэс 2.5 дахин нэмэгдсэн,

-Уул уурхайн салбарт 2017 онд шинээр бий болсон ажлын байранд Дорноговь аймгаас 356 иргэн ажилласан, уул уурхайн компаниудаас 2017 онд орон нутгийн иргэдээс нийт 39 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч, 300.0 гаруй сая төгрөгийн орлого оруулсан, Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 28 авто машиныг орон нутгийн дугаартай болгосон,

2018 он: “Хамтран ажиллах гэрээ”-г 56 аж ахуйн нэгжтэй байгуулсан нь урьд оноос 8 ААН-ээр нэмэгдсэн. Уг гэрээг ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй ажиллах, татварын өргүй байх, орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх гэсэн үндсэн 5 ажлын хүрээнд байгуулсан,

-Гэрээний үр дүнд 17 аж ахуйн нэгж орон нутгийн 481 иргэнийг ажлын байраар хангасан нь өмнөх оны мөн үеэс 35.1%- аар өссөн,

Уул уурхайн компаниудаас 2018 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогод 28 компани 1.701,9 сая төгрөг, өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны татварт 5 компани 74.2 сая төгрөг, Нүүрсний агаарын бохирдлын төлбөрт 5 компани-545.9 сая төгрөг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрт 19 компани-166.4 сая төгрөг, Ус ашигласны төлбөрт 45 компани- 200.6 сая төгрөгийг тус тус төвлөрүүлэн нийт 2.689.1 сая төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин нэмэгдсэн,

2019 он: “Дорноговь хариуцлагатай уул уурхай-хамтын ажиллагаа” зөвлөгөөнийг зохион байгуулсан, Уул уурхайн компаниудтай нийгмийн болон байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэх, сум орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих, татварын өр төлбөргүй ажиллах, ажиллах хүчний 60 хүртэлх хувийг орон нутгаас авч нийгмийн даатгалд бүрэн хамруулах, хүнс, бараа, ажил үйлчилгээ авахдаа сум, орон нутгийн ААН, иргэнд тэргүүн ээлжинд санал тавих зэрэг асуудлуудыг зөвшилцөн тайлант хугацаанд “Хамтран ажиллах гэрээ”-г 217 компанитай байгуулсан,

-Гэрээний үр дүнд орон нутгийн 994 иргэн ажлын байраар хангагдаж, орон нутгийн төсөвт 8,6 тэрбум төгрөг орон нутгийн төсөвт төвлөрч, 14 салбар, чиглэлийн 155 төрлийн бараа, 20 гаруй төрлийн үйлчилгээг орон нутгаас авч 1.0 тэрбум орчим төгрөгийн худалдан авалт хийсэн нь 2016 онтой харьцуулахад 35 хувиар өссөн гэж тус тус тайлагнасан байна.

Бодлогын баримт бичиг дэх зорилтын биелэлтийн эдийн засгийн үзүүлэлт, тоо хэмжээ, өсөлтийг аудитаар үзээгүй болно. Харин аудитад хамрагдсан асуудлын хүрээнд уул уурхайн компаниуд авто машины татвар төлөөгүй, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй, компани тус бүрээр байгуулсан гэрээний биелэлт, үр дүнг тооцоогүй, зарим компаниуд хуулийн дагуу холбогдох менежментийн төлөвлөгөө, тайланг аймаг, сумын ЗДТГ-т хариуцлагатайгаар хугацаанд нь ирүүлээгүй, шаардаж аваагүй, уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах ямар ажил зохион явуулсан нь тодорхой бус, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээсэн тухай нэгтгэсэн мэдээ судалгаа байхгүй байгаа нь байгууллагуудаас авсан судалгаагаар нотлогдож байна.

Б.1.2 Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилт бүрэн хангагдаагүй байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

2017 онд: “Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхийг дэмжиж, тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын удирдлагуудыг оролцуулсан уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулан гэрээний хэрэгжилтийг дүгнэн, үр дүнг тооцож ажиллана”, “Уул уурхайн болон томоохон хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчдийг түшиглэн жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна”,

2018 онд: “Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхийг дэмжиж, уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах, зорилт”, “Уул уурхайн салбар дахь байгаль орчны доройтлыг бууруулах чиглэлээр уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллана, байгаль орчинд сөрөг нөлөөлж буй үйлдвэр, уул уурхайн үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагын оролцоотойгоор хяналт тавина”,

2019 онд: Уул уурхайн болон бусад томоохон компаниудтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулна, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээх ажлыг хийнэ” гэсэн зорилтыг тус тус дэвшүүлсэн байна.

Бодлогын баримт бичигт тусгасан зорилтуудаас тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын удирдлагуудыг оролцуулсан уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулах, уул уурхайг төлөвшүүлэхийг дэмжинэ гэсэн зорилт хангагдсан байна.

Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ гэсэн зорилт бүрэн хэрэгжээгүй, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулна, байгаль орчинд сөрөг нөлөөлж буй үйлдвэр, уул уурхайн үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагын оролцоотойгоор хяналт тавина гэсэн зорилт хангагдаагүй байна.

Уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд Хутагтын ой болон аймаг, сумдын баяр наадмын арга хэмжээ, төрийн байгууллагуудад болон тэмцээн уралдаанд оролцож буй иргэд, Дорноговь хөгжлийн сан зэрэгт мөнгөн хандив, эд материал, тээврийн хэрэгсэл, ажиллах хүчний дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна.

Б.2 Талуудын хамтран ажиллах гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

Б.2.1 Гэрээнд байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг тусгасан ч хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилтын дагуу аймгийн Засаг дарга 2017 онд уул уурхайн 20 ААНБ-тай, 2018 онд 56 ААНБ-тай гэрээ байгуулжээ. 2019 онд уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий нийт 140 компаний 48.5 хувь буюу 68 уул уурхайн компаниудтай хамтран ажиллах гэрээг байгуулсан байна.

Хамтран ажиллах 2018 оны гэрээний хэрэгжилтийн тайланг 2019 онд Эко хэлхээ ХХК, Арвижих энерги ХХК, Монголиан флюор спар ХХК, Хөх бишрэлт ХХК, Арвин хад ХХК зэрэг 5 компани ирүүлсэн байх ба 2017 онд компаниуд гэрээний хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй, 2019 оны гэрээний хэрэгжилтийн тайлан ирүүлэх хугацаа болоогүй байна.

Аймгийн Засаг даргад ирүүлсэн компаниудын тайлангаас үзэхэд:

Эко хэлхээ ХХК: 2018 онд орчны шинжилгээ, хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан агаар, ус, хөрсний шинжилгээг нэг удаа Дорноговь аймгийн УЦУОШТ-ийн лабораторид хийлгэсэн. Ахуйн хог хаягдлаа ялган сумын төвийн хогийн цэгт тээвэрлэн хүргэсэн, сумын ЗДТГ-т сумын хог хаягдлыг тээвэрлэх өөрөө буулгагч хогны машин хандивласан байна.

Арвижих энерги ХХК: 2018 оны БОМТ боловсруулсан. Даланжаргалан сумын Элдэв багийн иргэдэд хийгдэж байгаа ажлаа танилцуулж, иргэдийн саналыг авч цаашдын төлөвлөгөөнд оруулахаар болсон байна.

Монголиан флюор спар ХХК: Гэрээний дагуу усны зохистой хэрэглээг хангах зорилгоор хаягдлын сангаас усаа буцаан татаж үйлдвэрлэлийн усны хэрэглээний 80 хувийн саарал усыг дахин ашигладаг. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагддаг агаар, ус хөрс, хүдэр, баяжмалын шинжилгээг Геологийн төв лабораториос 8 хүний бүрэлдэхүүнтэй багаар шинжилгээ хийлгэжээ.

Хөх бишрэлт ХХК: Сумын ЗДТГ-тай хог хаягдлын гэрээ байгуулсан ба хураамжийг цаг бүрт нь төлсөн, үйлдвэрээс гарсан ахуйн хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт хаясан, техник хүн хүчний туслалцаа үзүүлэн хогийн талбайг цэвэрлэсэн байна. Сумын ЗДТГ болон төсвийн байгууллагуудын албан хаагчдад явган аялал зохион байгуулж, үйлдвэрийн үйл ажиллагааг танилцуулсан байна.

Арвин хад ХХК: Уулын ажлын төлөвлөгөө болон БОМТ-нд тусгасан /уурхайн олборлолтын эхний жилүүд тул нөхөн сэргээлт хийгдээгүй/ тэмдэгжүүлэлт, орчны

шинжилгээ хийлгэсэн. БО-ны нөхөн сэргээлтийн санд 2.5 сая төгрөг байршуулсан гэсэн тайлан ирүүлсэн байна.

Аудитын тайланд өгсөн саналд ирүүлсэн мэдээллээр аймгийн хэмжээнд нийт 29 уул уурхайн компанийн бүтээгдэхүүний тээвэрлэлт хийх 1388.9 км замын маршрут тогтоогдсоноос 205.2 км замыг сайжруулсан байна.

Гэрээнд тусгасан заалтуудаас дараах асуудал хэрэгжээгүй байна.

- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тайланг олон нийтэд танилцуулж, нутгийн иргэдийг мэдээллээр хангах ажлыг тухай бүр нь төсөл хэрэгжиж байгаа сумын болон аймгийн Засаг даргатай хамтран зохион байгуулна.
- Аймаг болон сумдын төрийн байгууллагууд, нутгийн иргэдийг уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.
- Усны зохистой хэрэглээг хангах зорилгоор үйлдвэрлэлд дэвшилтэт технологи ашиглаж, газрын доорхи усны дотоодын хяналтын сүлжээг байгуулж усны хэрэглээг тоолууржуулна.
- Биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх ажилд хамтран ажиллана

Б.2.2 Үйл ажиллагаа явуулсан компаниуд ажлын байр нэмэгдүүлж ажилласан байна.

Ажлын байр нэмэгдүүлэх дараах асуудлыг гэрээнд тусгасан байна. Үүнд:

- Ажиллах хүчний тодорхой хувийг сум, орон нутгаас авч ажиллуулна.
- Компани нь орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сургахад аймаг орон нутгийн захиргаатай хамтарч шаардлагатай ажлын байр, тавигдах шаардлагыг тухай бүр олон нийтэд зарлана.
- Компани нь нарийн мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдыг шаардлагатай тохиолдолд дотоод, гадаадын их, дээд сургуульд өөрийн зардлаар сургаж мэргэшүүлж болно.
- Компани нь МУ-ын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудад бакалаврын түвшинд суралцаж буй аймгаас шалгарсан оюутнуудад санхүүгийн туслалцаа үзүүлдэг тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. Компани төслийн үйл ажиллагаа явуулж буй сумын сургууль, цэцэрлэгийг сайжруулахад дэмжлэг үзүүлж аймаг болон сумтай хамтран ажиллана.
- Компани нь аймгийн иргэдэд мэргэжил олгох шаардлагатай ур чадвар, мэдлэг, практик, туршлага эзэмшүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.
- Компанийн ажиллагсдыг гэнэтийн осол, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамруулна.
-

Гэрээний заалтуудыг хэрэгжүүлсэн байдал:

Эко хэлхээ ХХК: Дорноговь аймгийн харьяат 55 хүн ажиллуулснаас 46 нь Даланжаргалан сумын иргэд байна. Нийт ажиллагсдын цалин 700.0 мянган төгрөгөөс дээш хэмжээгээр тогтоогдсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэнийг ажиллуулсан, мөн 2018 онд Дорноговь аймгийн Ажил олгогч эздийн холбооны зүгээс Дорноговь аймгийн хэмжээгээр хамгийн олон ажлын байр шинээр бий болгосон ААН-ээр шалгарсан тухай тайлан ирүүлсэн байна.

Арвижих энерги ХХК: Уурхайгаас Олон Овоо хүртэлх 30 км зайд нүүрс тээвэрлэх ажлыг орон нутгийн жолооч иргэдээр гүйцэтгүүлж байгаа, орон нутгийн 6 ажилчин авч ажиллуулснаас гаалийн бүрдүүлэлтэд 1, галч 2, ковшийн оператор 3 ажиллаж байна гэжээ.

Монголиан флюор спар ХХК: Мэргэжил шаардахгүй ажлын байрны ажилчдын 72.9 хувийг Дорноговь аймгийн иргэд эзэлдэг, сумын нэг иргэний их дээд сургуулийн нэг жилийн сургалтын төлбөрийг даан суралцуулжээ.

Хөх бишрэлт ХХК: Үйлдвэрийн 82 ажиллагсдын 57 нь орон нутгийн иргэд бөгөөд үйлдвэр өмнөө тавьсан зорилтоо хангасан учир нийт ажилчдыг 40.0 гаруй сая төгрөгийн цахилгаан бараа болон мөнгөн шагналаар шагнажээ.

Арвин хад ХХК: Гөлтгөнө тээвэрлэхэд орон нутгийн тээврийн машин бүхий 5 жолооч оролцсон. Вогон ачилт болон уурхайн тогооч зэрэг ажилчдыг орон нутгаас авч ажиллуулсан байна.

Б.2.3 Компаниуд орон нутгийн төсөвт төлөх гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлжээ.

Хамтран ажиллах гэрээнд орон нутгийн төсөвт төлөхөөр дараах асуудлыг тусгасан байна.

- Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хуулийн дагуу орон нутгийн татварыг аймгийн Татварын хэлтэст тайлагнаж, аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлж татварын өр төлбөргүй ажиллана.
- Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах хугацаанд Улсын бүртгэлийн хуулийн этгээдийн салбарын гэрчилгээ авна.
- Газрын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн газар ашиглах эрхийг баталгаажуулна.
- Ажиллагсдыг гэнэтийн ослын болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.
- Монгол улсын хуулийн дагуу орон нутгийн татварыг тайлагнаж, нийгмийн даатгалын болон татварын өр төлбөргүй ажиллана.
- Компанид бүртгэлтэй, Дорноговь аймагт ажиллах тээврийн хэрэгслийг орон нутгийн дугаартай болгох /2017 оны гэрээнд тусгасан/

Тайлан ирүүлсэн компаниуд Хутагтын ой болон баяр наадмын арга хэмжээнд мөнгө хандивласан байна. Хөх бишрэлт ХХК ахмадын баяраар 6 ахмадад гэр хандивласан, Грийн энерги проспекити ХХК Адуучин нэвтрүүлэгт мөнгөн дэмжлэг үзүүлсэн тухай тайлагнасан байна. Тээврийн хэрэгслийг орон нутгийн дугаартай болгож татвар төлсөн ААНБ цөөхөн байна.

МХГ-ын шалгалтаар уул уурхайн компаниуд ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, гэрээ байгуулаагүй, усны төлбөр төлөөгүй, хогны төлбөрийг зарим компани төлөөгүй зөрчил жил дараалан гарсан байна.

Орон нутгийн төсөвт төлсөн татвар хураамжийг судалж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1.Татварын хэлтсээс авсан судалгаа буюу уул уурхайн компаниудаас 2017-2019 онд төлсөн ХХОАТ болон тээврийн хэрэгслийн татвар төлөлтийг хүснэгт №3-аар харуулав.

Хүснэгт №3

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт		2019 он	2018 он	2017 он
1	ХХОАТ	ААНБ-ын тоо	30	27	22
		Төлсөн татвар	1987.2	1810.6	1570.0
2	Тээврийн хэрэгслийн татвар	ААНБ-ын тоо	10	4	4
		Төлсөн татвар	7.4	2.9	3.4

2.ГХБХБГ-аас авсан судалгаа буюу 2017-2019 оны байдлаар уул уурхайн компаниудаас төлбөл зохих газрын төлбөр 1935.7 сая төгрөг байгаа бол 643.0 сая төгрөг төлж нийт дүнгээрээ газрын төлбөрийн дутуу төлөлт 1292.7 сая төгрөг байна. Үүнээс Айраг, Хатанбулаг суманд төлөгдсөн газрын төлбөрийн илүү төлөлт 14.0 сая төгрөгийг хасахад 8 суманд 1306.7 сая төгрөгийн газрын төлбөр дутуу төлөгдсөн байна.

Сумдад газрын төлбөрийн ногдуулалт, төлсөн төлбөрийг хүснэгт №4-өөр харуулав.

Хүснэгт №4

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2019 он		2018 он		2017 он		Нийт дутуу төлсөн дүн
		Төлвөл зохих	төлсөн	Төлвөл зохих	төлсөн	Төлвөл зохих	төлсөн	
1	Айраг	16.5	20.5	12.4	15.4	13.7	11.7	-4.9
2	Алтанширээ	296.7	74.8	1.4	0.7	1.4	0.9	223.0
3	Даланжаргалан	194.8	118.2	35.7	26.9	33.6	30.7	88.3
4	Дэлгэрэх	20.9	0	0.07	0.07	1.5	1.5	20.9
5	Иххэт	31.3	13.8	8.1	9.3	9.5	7.9	17.9
6	Мандах	55.1	55.1	31.1	31.0	31.0	31.0	0.1
7	Өргөн	109.1	53.5	15.9	18.1	6.5	4.0	55.9
8	Сайхандулаан	153.2	25.3	5.4	3.6	5.9	3.9	131.7
9	Улаанбадрах	776.7	7.3	18.1	18.4	6.2	6.2	769.0
10	Хатанбулаг	11.2	20.1	6.2	6.4	16.9	16.9	-9.1
11	Хөвсгөл	0	0	4.7	4.7	4.7	4.7	0
	Дүн	1665.5	388.6	138.1	134.7	130.8	119.4	1292.7

Хүснэгт №4 дэх дутуу төлсөн дүнгийн 80-аад хувийг эзэлж буй газрын төлбөрийн 50.0 сая төгрөгөөс дээш өртэй байгаа компаниудыг хүснэгт №5- харуулбал:

Хүснэгт №5

	Компанийн нэр	Талбай байрших сумын нэр	Тусгай зөвшөөрлийн тоо	Газрын хэмжээ /га/	Газар ашиглуулах шийдвэр гарсан огноо	Төлбөрийн дүн /сая төгрөг/
1	Бадрах энерги ХХК	Улаанбадрах	3	48375.77	2019.06.17	774.0
2	И Си Эм ХХК	Алтанширээ	1	5977.9	2018.07.04	95.6
3	Алаг толгой ХХК	Даланжаргалан	1	5488.42	2017.07.24	87.6
4	Фрийгүүд ХХК	Сайхандулаан	1	3959.69	2016.09.21	63.3

Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн /сумын газрын даамлын эрх, үүрэг/ 23.4.5-т “Газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж, хураах” гэж заасан бол Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ газрын төлбөрийн ногдуулалтын

жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, ногдуулалтын эцсийн тооцоог хийнэ”, мөн зүйлийн 10.4-т “Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина” гэж тус тус заасан байна. Аудитаар холбогдох мэдээллийг сум, орон нутгаас авч ажиллах явцад хэд хэдэн сумдын байгаль орчны байцаагч, газрын даамал солигдон ажилласан, орны хүн томилогдоогүй гэсэн тайлбар гарч байлаа. Энэ байдлаас шалтгаалж хариуцсан ажил эзэнгүйдэх, төлбөр хураамжийг хугацаанд нь төлүүлэх, хяналт тавих үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжсэн байна.

Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Эзэмшиж, ашиглаж байгаа хот, тосгон, бусад суурины газрын суурь үнэлгээнд тогтоосон газрын төлбөрийг инженерийн хангамж, ашиглалтын зориулалт, байршил, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон ногоон бүсийг хамгаалах шаардлагыг харгалзан тооцсон итгэлцүүрээр энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан хязгаарт багтаан өсгөж, бууруулж болно. Итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж заасан байна.

ГХБХБГ-т тусгай зөвшөөрөл бүхий нийт талбайн зөвхөн ашиглагдаж байгаа газарт төлбөр төлөх асуудлаар хэд хэдэн компаниас /Бадрах энерги ХХК.../ гомдол, санал ирүүлсэн байна. Тухайлбал: Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2018 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар” нь улсын бүртгэлд бүртгэгдэж Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлэгдээгүй, Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж байгаа хэсэгт зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг ойр орших улс, аймгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан хоёр дахин өсгөж тооцно” гэсэн заалтыг зөрчиж байна гэсэн гомдол санал ирүүлжээ.

Газрын төлбөрийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Газрын төлбөртэй холбогдон үүссэн дараахь маргааныг дор дурдсан байгууллага, албан тушаалтан хянан шийдвэрлэнэ”, 11.1.1 “төлбөр төлөгч болон газрын асуудал эрхэлсэн албаны холбогдох албан тушаалтны хооронд үүссэн маргааныг тухайн албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтан”; 11.1.2 “төлбөр төлөгч болон Засаг даргын хооронд үүссэн маргааныг тухайн Засаг даргын дээд шатны байгууллага, албан тушаалтан” гэж тус тус заасан байна. ГХБХБГ-аас Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт дээрх асуудлаар албан бичиг хүргүүлсэн ч хариу шийдвэр ирүүлээгүй байна.

Иймд Газрын төлбөрийн тухай хуулийн дээрх заалтын дагуу дараа дараагийн байгууллагад хандан газрын төлбөрийг асуудлыг шийдвэрлэж хуулийн хүрээнд газрын төлбөрийг төлүүлэх хэрэгтэй байна.

Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Газрын төлбөрийг газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно” гэж заасныг хэрэгжүүлж газрын төлбөрийн ногдуулалтыг хийх нь зүйтэй байна.

3. БОАЖГ-аас авсан судалгаагаар 2019 онд усны төлбөрийг 250.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 289.2 сая төгрөг байна. Энэхүү судалгаанд бүх байгууллагуудын усны төлбөр орсон болно. Ашиглалтын тусгай зөвшөөрөл, баяжуулах, боловсруулах үйлдвэр олон байдаг Даланжаргалан, Айраг, Иххэт, Өргөн Сайхандулаан сумын усны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг

харахад дараах байдалтай байна. Хүснэгт № 6-д усны төлбөрийн орлогын төлөвлөгөө, орсон орлогыг зарим сумдаар харуулав.

Хүснэгт №6

Сумын нэр	Ашиглалтын ТЗ-ийн тоо	Төлөвлөгөө /сая төгрөг/	Гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/
Айраг	30	32.2	6.9	-25.3 дутуу
Даланжаргалан	72	129.8	124.4	-5.4 дутуу
Иххэт	18	3.8	5.9	2.1 илүү
Өргөн	18	8.0	7.2	-0.8 дутуу
Сайхандулаан	10	8.1	3.3	4.8 дутуу

Усны төлбөрийн орлогыг дутуу төлөвлөдөг, төлөвлөсөн хэмжээгээр төлбөрийг төлөөгүй байна.

Усны тухай хуульд аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд: Усны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д “Усны тухай хууль тогтоомжийн биелэлтийн явцад хяналт тавьж, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах” 18.1.4-т “Ус ашиглагчид сав газрын захиргааны шийдвэр, энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулах, усны мэдээллийн санд бүртгэх”

Мөн хуулийн 19 дүгээр зүйлд сум, дүүргийн байгаль хамгаалагчийн бүрэн эрх буюу 19.1.4-т “энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож бүртгэх, мэдээллийг сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх” гэж тус тус заасан байна.

Гэтэл МХГ-ын шалгалтаар уул уурхайн компаниудад ус ашиглах гэрээгүй, ус ашиглах дүгнэлтгүй, ус ашиглах эрхийн бичиггүй, ус ашиглах төлбөр төлөөгүй гэсэн зөрчил нийтлэг гарснаас харахад БОАЖГ, сумын байгаль орчны байцаагч нарын ажлын уялдаа сул, хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

4.НДХ-ээс авсан судалгаагаар 2017-2019 онуудад НДШ төлдөг уул уурхайн компаниуд 355.4-601.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй гарчээ. Хүснэгт №7-д НДШ төлөлтийг харуулав.

Хүснэгт № 7

Үзүүлэлт		2019 он	2018 он	2017 он
Даатгуулагчийн тоо		1299	1794	1053
Төлсөн шимтгэл	Компанийн тоо	24	28	18
	НДШ төлсөн дүн /сая төгрөгөөр/	2467.9	2363.0	1819.9
Шимтгэлийн өр	Компанийн тоо	8	12	11
	НДШ-ийн өглөгийн дүн /сая төгрөгөөр/	601.7	612.6	355.4

2019 оны байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн 601.7 сая төгрөгийн өртэй 8 компани байна.

Гэрээнд Монгол улсын хуулийн дагуу орон нутгийн татварыг тайлагнаж, нийгмийн даатгалын болон татварын өр төлбөргүй ажиллана гэж заасныг хангалтгүй хэрэгжүүлжээ. Иймд уул уурхайн компаниудаас орон нутгийн төсөвт оруулах орлогыг нэр төрлөөр бүрэн тооцож төлөвлөх, төсөвт төвлөрүүлэх, өр төлбөрийг барагдуулах хэрэгтэй байна.

Б.2.4 Уул уурхайн компаниуд эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй ажиллагааг хангах гэрээний үүргээ хангалтгүй биелүүлжээ.

Ашигт малтмалын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой үйл ажиллагаа явуулна” гэж заасан байна. Хамтран ажиллах гэрээнд:

- Гамшиг, осол гарсан тохиолдолд сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад туслалцааг өөрийн нөөц бололцоон дээр тулгуурлан туслалцаа үзүүлнэ,
- Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, одой хүнийг ажлын байраар хангах буюу ажиллуулаагүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу мөнгөн төлбөрийг орон нутгийн ХЭДС-нд төлнө гэж тусгасан байна.

Эко хэлхээ ХХК хөгжлийн бэрхшээлтэй 3 хүний авч ажиллуулсан байх ба бусад компаниуд ХБИ авч ажиллууллаагүйн төлбөрийг төлөөгүй байна. Монголиан флюор спар ХХК гамшгаас болж хохирсон байгууллага иргэдэд машин техникийн тусламж үзүүлсэн байна.

Хөх бишрэлт ХХК 2018 онд цасан шуурганд мал нь дарагдсан 2 хот айлын малын хороог засахад техникийн туслалцаа үзүүлсэн, сумын хэмжээний онцгой байдлын сургалтад орон байр, техник, хүн хүчээр тусалсан байна.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, одой хүнийг ажлын байраар хангах буюу ажиллуулаагүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу мөнгөн төлбөрийг орон нутгийн ХЭДС-нд төлнө гэсэн заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. Хяналтаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан компаниудад ашигт малтмалын болон бусад холбогдох хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах асуудлаар үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай байна.

В.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль журмын заалтыг мөрдөөгүйгээс байгаль хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

В.1.1 Холбогдох байгууллагуудын ажлын хариуцлага сул, хяналт хангалтгүй байгаагаас хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө хянуулж батлуулах, тайлагнах ажил хангалтгүй байна.

Дорноговь аймгийн нийт газар нутгийн 10.2 хувь буюу 1116.2 мянган гектар талбайд 173 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байна. Сумдын газар нутгийн хэмжээ, хамрагдсан хайгуулын талбай, газарт нутагт эзлэх хувийг хүснэгт №8-д харуулав.

Хүснэгт №8

Сумдын газар нутагт хайгуулын талбайн эзлэх
хувь хэмжээ /2019.10.03/

Сумдын нэр	Газар нутгийн хэмжээ мян.га	Хайгуулын талбай мян.га	Газар нутгийн эзлэх хувь
Айраг	744.30	22.4	3.02
Алтанширээ	722.60	37.4	5.17
Даланжаргалан	404.60	41.0	10.15
Дэлгэрэх	485.80	68.5	14.10
Иххэт	415.20	13.7	3.31
Мандах	1,266.10	232.4	18.36
Өргөн	869.90	77.9	8.95
Сайншанд	234.30	57.5	24.55
Сайхандулаан	955.80	134.4	14.06
Улаанбадрах	1,137.10	131.1	11.53
Хатанбулаг	1,866.90	168.8	9.04
Хөвсгөл	837.70	35.1	4.19
Эрдэнэ	959.20	77.0	8.03
Дүн	10,899.50	1,116.2	10.2

2019 онд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 46.8 хувь буюу 81 ААНБ менежментийн төлөвлөгөө боловсруулан БОАЖГ-аар хянуулж батлуулсан байна. Дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хайгуулын талбай нь тус аймагт хайгуул хийгдэж буй нийт талбайн 43.4 хувийг эзэлж байна.

Хүчин төгөлдөр хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ихэнх нь 2019 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж холбогдох газраар хянуулж батлуулаагүй, байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг дутуу болон байршуулаагүй байна. Тухайлбал: Дутуу байршуулсан компанийг дурдвал

- Хэрлэн голын үйлс ХХК /XV-013406/: Айраг сумын Хойд хонгор нэртэй 2.2 мянган гектар хайгуулын талбайтай,
- Хутагт өлзийт говь /XV-020284/: Даланжаргалан сумын Чулуут нэртэй 1.0 мянган гектар хайгуулын талбайтай,

- Чингис ворлд майнинг ХХК /XV-019358/: Айраг сумын Үнэгт нэртэй 6.5 мянган гектар хайгуулын талбайтай,

Тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулаагүй компани:

- Арвижих энерги ХХК /XV-020830/: Даланжаргалан сумын Далан нэртэй 3.6 мянган гектар хайгуулын талбайтай,
- Хасрич ХХК /XV-020010/: Даланжаргалан сумын Хөндий нэртэй 0.03 мянган гектар хайгуулын талбайтай
- Мөнгөнхас шонхор ХХК /XV-019783/: Даланжаргалан сумын Бурхант нэртэй 0.3 мянган гектар хайгуулын талбайтай,
- Церкон геологи ХХК /XV-020083/: Даланжаргалан Бурхант нэртэй 0.3 мянган гектар хайгуулын талбайтай,

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим ААНБ байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.1-д “Тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах”, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-05 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 1.4-д Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны алба хянаж, батална” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Мөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим ААНБ сумын Засаг даргатай зөвшилцөж байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хүргүүлэх ажил хангалтгүй байна. Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.8-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг зөрчиж байна.

Байгаль орчны асуудал эрхэлсэн орон нутгийн төрийн захиргааны байгууллагын ажил хариуцсан албан тушаалтны ажлын хариуцлага, холбогдох хяналтын байгууллагуудын хяналт хангалтгүй байгаагаас хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянуулж батлуулах, тайлагнах ажил хангалтгүй байна.

В.1.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг бүрэн ирүүлээгүй, тайланг шаардаж аваагүй байна.

Дорноговь аймгийн хэмжээнд 140 гаруй ХХК-д 185 ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Эдгээрээс сүүлийн 3 жилийн хугацаанд дунджаар 30 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулжээ.

Аймгийн хэмжээнд боловсруулах, баяжуулах үйлдвэр бүхий 16 ААНБ үйл ажиллагаа явуулдаг байна. Тухайлбал жонш баяжуулах 6, төмрийн хүдэр

баяжуулах 1, ширэм боловсруулах 1, цемент боловсруулах 3, цахиур боловсруулах 1, шохой боловсруулах 1, нүүрс угаах 2, металл боловсруулах 1 үйлдвэр байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.6-д “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдмагц тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тэдгээрийн хуулбарыг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон Байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх”, 39.1.7-д “Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг жил бүр гарган байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлнэ” гэж заасан байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-05 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” 4.1-д “Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 2-р хавсралтын дагуу гаргаж, төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлнэ” гэж тус тус заасан байна.

Аймгийн ЗДТГ-т ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий компаниудаас БОНБУ, тухайн жилийн БОМТ-ний хуулбар хувь болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ирүүлээгүй байна.

Аудитын хугацаанд Айраг, Даланжаргалан сумын ЗДТГ-ын байгаль орчны байцаагч, Айраг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Мон ли да ХХК, Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Эко хэлхээ ХХК, Олон их баян ХХК-ийг хамруулж үйл ажиллагаанд аудит хийсэн.

Айраг сум. Тус суманд 2018 онд БОНБУ, БОМТ ирүүлсэн 6 ААНБ, 2019 оны байдлаар зөвхөн Эм си ти ти ХХК БОМТ болон тайланг ирүүлсэн байна. Тус суманд үйл ажиллагаа явуулсан 11 компани хог хаягдлын гэрээ байгуулж компани тус бүр жилд 180.0 төгрөг төлөх төлбөрөө бүрэн төлсөн, ус ашиглах дүгнэлт гаргуулсан, ус ашиглах гэрээ байгуулсан байна.

Сумын Засаг даргын 2019 оны А/141 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2019 оны 7 сарын 23, 24-ний өдрүүдэд ашигт малтмал олборлож буй 6 ААНБ-д хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар Эм Си Ти Ти ХХК ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өртэй, ШТС-ын галын дүгнэлт гаргуулаагүй, тээврийн маршрутын замаа сайжруулаагүй, нөхөн сэргээлтийн тайлан ирүүлээгүй, Мин ли да ХХК гадаадын харьяат иргэдийн бүртгэлийг сумын ЗДТГ-т бүртгүүлээгүй, Дорнын говийн үйлс ХХК ашиглалтын талбайгаа хашаажуулаагүй, гадаад 2 иргэнийг орон нутагт бүртгүүлээгүй, хог, усны гэрээ байгуулаагүй, Бужгар орд ХХК ус ашиглах гэрээ байгуулаагүй зэрэг зөрчил илрүүлж хугацаатай үүрэг даалгавар өгчээ.

Сумын ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 9, 12 дугаар сард уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг ААНБ, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ, нөхөрлүүдэд шалгалт хийсэн байна. Шалгалтаар уул уурхайн ачаа тээвэрлэх замын маршрут батлуулаагүй, засмал замаар ачаа тээвэрлэхдээ жин хэтрүүлсэн, батлуулсан компани тээвэрлэлтээ маршрутын дагуу хийгээгүй зөрчил илрүүлсэн байна.

Даланжаргалан сум. Тус суманд 2018 онд 7 ААНБ-аас БОМТ ирүүлсэн, 2 ААНБ БОМТ-ний тайлангаа ирүүлсэн, 2019 онд 11 ААНБ БОМТ ирүүлсэн байна. ААНБ-

ууд БОМТ-ний хэрэгжилтийг 2019 оны 10, 11 дүгээр сард ирүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан байтал нэг ч газраас тайлан ирүүлээгүй байна.

Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 4 дүгээр сард 15 компанийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна. Шалгалтаар Хүдрэнт ХХК, Наймган орд ХХК, Дөрвөн талст Эрдэнэ ХХК, Фэн шун зун ХХК, Давхар амжилт ХХК, Блюскай хорс ХХК, Айраг эксплорэйшн ХХК-ууд ажлын байранд байх бичиг баримтгүй, газар, усны гэрээ хийгдээгүй, худгийг тоолууржуулаагүй, хог хаягдлын гэрээ байгуулаагүй, Олон-Ихт баян ХХК хог хаягдлын ялгалт хийдэггүй, эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, газрын зөвшөөрөл аваагүй барилга байгууламж барьсан, Дүншинхэние ХХК хог хаягдлаа ялгадаггүй, эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, Чингисийн хар алт ХХК далангийн ус нь шүүрч их хэмжээгээр урссан, Даурлэнд ХХК-ийн туслан гүйцэтгэгч Ховолжийн ундарга ХХК-ын гадаадын иргэд ямар ч бичиг баримтгүй, уурхай дээр байх бичиг баримтгүй, усны дүгнэлт гаргуулаагүй, эрүүл ахуйн бүс тогтоолгоогүй, хог хаягдлын ангилан ялгалт хийгээгүй зөрчил илэрсэн байна. Зөрчил бүхий 5 ААНБ-ын 17 техникт лац тавьж, тоолуургүй ААНБ-д мэдэгдэх хуудас хүргүүлж зөрчил арилгах шаардлага тавьсан байна.

Данжаргалан сумын ИТХ-аас 2008-2018 онуудад иргэн, ААНБ-аас ирүүлсэн газрын хүсэлтүүдийг хэлэлцэн гаргасан шийдвэрүүдийн нэгтгэлийг 2018 онд, Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, эрх зүйн орчин гэсэн тохимолыг 2019 онд тус тус гаргасан байна.

Компаниуд. Мон ли да ХХК уурхай дээр байлгавал зохих бичиг баримтууд бүрэн, газар ашиглах, ус ашиглах гэрээг байгуулсан, хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн тайлан гаргаагүй, Олон их баян ХХК БОНБУ гараагүй, БОМТ хийгдээгүй, хамтран ажиллах гэрээ байгуулаагүй байна. Эдгээр компанийн төв офисс Улаанбаатар хотод байрладаг тул төлбөр хураамж болон мэдээллийг авч чадаагүй болно.

Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт орших “Кевин инвест” ХХК-ийн хайлуур жонш баяжуулах үйлдвэрийг Эко хэлхээ ХХК 2018 оноос эхлэн түрээсийн гэрээгээр ашиглажээ. Эко хэлхээ ХХК 2019 оны БОМТ байхгүй, ус ашиглах дүгнэлт, гэрээ байхгүй байв. Харин 2018 оны хамтран ажиллах гэрээний тайланг хүргүүлсэн байлаа.

Тус компани “Монгол Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны Ус ашиглуулах дүгнэлтээр усны төлбөрийн хэмжээг 97.0 сая төгрөгөөр тооцсоноос 53.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. 2019 онд хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулахдаа ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй, “Умарт говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа”-аас ус ашиглах зөвшөөрөл аваагүй, үйлдвэрлэлийн зориулалтаар 6 ш гүний худгаас ус ашиглаж, төлбөрийг барагдуулаагүй байна.

Энэ нь Усны тухай хууль 28.11-д “Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ”, 28.6-д “Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ”, 29.1-д “Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн..., төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга ус ашиглах гэрээ байгуулна”, 31.1-

д "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө" гэсэн заалтыг тус тус зөрчиж байна. Аудитын явцад тус компанид зөрчлүүдийг барагдуулах талаар зөвлөсөн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр усны төлбөр 50.0 сая төгрөг төлсөн байна.

Эко хэлхээ ХХК-ийн 2019 онд үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны бодит хэмжээг гаргуулж, төлбөрийг барагдуулах ажлыг сумын Засаг дарга, холбогдох мэргэжилтэнд хариуцуулан албан шаардлага бичлээ.

Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 "Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчээс дутуу ирүүлсэн мэдээ, тайланг шаардах эрхтэй" гэж заасан байна. Байгаль орчны байцаагч, мэргэжилтнүүд мэдээ, тайланг тухай бүр шаардаж аваагүй, шалгалтаар илрүүлсэн зөрчлийг компаниуд давтан гаргасан байна.

В.2 Хяналтаар уул уурхайн компаниуд ашигт малтмалын болон холбогдох бусад хууль тогтоомж зөрчсөнийг илрүүлсэн байна.

В.2.1 Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан мэдээ тайлан байхгүй байна.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан мэдээ тайлан байхгүй байна. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан талаар АМГТГ-ын цахим хуудаснаас мэдээлэл авдаг байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн болон холбогдох мэдээ, тайлан, төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд мэргэжлийн хяналтын албанд хүргүүлдэггүй байна.

В.2.2 Ашигт малтмалын ашиглалтын зөвшөөрөл эзэмшигч компаниудад хяналт тавьж зөрчил илрүүлсэн хэдий ч хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих хяналт хангалтгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 11.3-т "Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ" гэж заасан.

МХГ 2017-2019 онд ашигт малтмалын **хайгуулын** үйл ажиллагаанд 1 удаа хяналт хийж, Айраг сумын нутагт орших Өсөн ХХК-ний уул уурхайн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж, 32 зөрчлийг илрүүлсэн байна. Тухайлбал:

- Хайгуулын ажлын тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж хугацаанд нь хүргүүлээгүй, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний тайлан байхгүй,
- Тусгай зөвшөөрөл бүхий талбайдаа архелогий болон плантелогийн судалгаа хийгээгүй
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй

Ашигт малтмалын хайгуулын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашигласан эсэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад тавих хяналт хангалтгүй байна.

Харин МХГ-аас тухайн оны төлөвлөгөө, удирдамж, Засаг даргаас өгөгдсөн үүрэг, иргэдээс ирүүлсэн санал, гомдлын дагуу аймгийн хэмжээнд **ашиглалтын** тусгай зөвшөөрөл эзэмшин уул уурхайн чиглэлээр ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дараах хяналт шалгалт хийсэн байна.

- 2017 оны 6 сард 23 аж ахуйн нэгжийг хамруулж зөвшөөрөлгүй болон бичиг баримтын зөрчилтэй 5 ААНБ-ын үйл ажиллагааг түр зогсоож, 7 ААНБ-д хугацаатай албан шаардлага өгч 3 ААН-д зөвлөмж хүргүүлсэн байна. Мөн тэсрэх материалыг зориулалтын бус газар хадгалсан Их говь энерги ХХК-д 2.4 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.
- МХГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 7 сард МАК элдвийн уурхайн үйл ажиллагаанд хяналт шалгалт, Даланжаргалан, Иххэт сумын нутагт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт явуулдаг МАК цемент ХХК, Кевин инвест ХХК, Баянтэгш импекс ХХК -ийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, Даланжаргалан сумын ИТХ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2018 оны 12 сард Эко хэлхээ ХХК-ийн жонш бутлах баяжуулах үйлдвэрлэл эрхэлж байгаа үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж Кевин инвест ХХК-д зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн байна.
- МХЕГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу МХЕГ, МХГ-ын хамтарсан шалгалтыг 5 чиглэлээр явуулсан байна. МХЕГ-ын дэд даргаар ахлуулсан хяналт шалгалтаар /2018 оны 11 дүгээр сар/ байгаль орчны хяналтын чиглэлээр хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүд БОНБУ-ээр тавигдсан шаардлага, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хийдэггүй, хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан сорьц дээжийг бүрэн авч шинжлүүлдэггүй, байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, хог хаягдлын хэмжээг бүртгээгүй, эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд мод тарьж зүлэгжүүлээгүй гэх мэт зөрчил илэрсэн байна. Тус шалгалтаар дараах газруудад зөвлөмж өгсөн байна. Үүнд:
-МУ-ын Засгийн газрын хэрэг эрхлэх газарт: Сумдын байгаль орчны улсын байцаагчдыг аймгуудын МХГ-т харьяалуулж босоо тогтолцоонд оруулах,
-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд: Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын уулын ажлын төлөвлөгөө тайланг батлахдаа МХБ-аар хянуулдаг байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, Ашигт малтмалын тухай болон Байгаль орчны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилладаггүй, олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийдэггүй, дахин олборлолтын үйл ажиллагаа явуулдаг ААНБ-дад хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлж тусгай зөвшөөрөл олгодоггүй байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах,
-Аймгийн Засаг даргад: Уул уурхай, баяжуулах үйлдвэрүүдийн цэвэр усны хэрэглээг тоолууржуулах, усны хэрэглээний төлбөр тооцоог баталгаатай хэмжих хэрэгслээр тооцоолох арга хэмжээ авч ажиллах, ашигт малтмал олборлох, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ууд тухайн жилдээ олборлолтын үйл ажиллагаа явуулсан талбайдаа техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгээгүй тохиолдолд дараа жилийн олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэхгүй байх арга хэмжээ авах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зөвлөмжийг тус тус өгсөн байна.
- МХЕГ-ын даргын тушаалаар баталсан 01/126 тоот удирдамжийн дагуу МХГ-аас 2019 оны 4 сард уул уурхайн 18 ААН, 13 нөхөрлөлд урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт хийсэн байна. Тус шалгалтаар газар, ус ашиглах гэрээ

байгуулаагүй, уурхайг байнга ашиглалтад хүлээн авсан комиссоос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, ус авах цэг, худгийг тоолууржуулаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтоогдсон шаардлагуудыг хэрэгжүүлээгүй, хөрсний элэгдэл, эвдрэлд орох бохирдохоос урьдчилан сэргийлээгүй, дотоод хяналтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшээгүй зөрчил илэрсэн байна.

- Аймгийн Засаг даргын 2019 оны 05 сарын 10-ны өдрийн А/426 дугаар захирамжаар батлагдсан "Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сумдын нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалт, боловсруулах, баяжуулах, бичил уурхайн чиглэлээр ажиллаж байгаа ААН-дийн үйл ажиллагаанд шалгалт хийх удирдамж"-ийн дагуу хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар 2019 оны 4-р сард илрүүлсэн зөрчилтэй адил зөрчил илрүүлжээ.
- МХГ-ын төлөвлөгөөний дагуу 2019 оны 10 сард төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн байна. Шалгалтад 8 ХХК хамрагдсан бөгөөд Кивен инвест ХХК-ийг зөрчил арилгах хүртэлх хугацаанд үйл ажиллагааг түр зогсоох акт, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахад чиглэсэн 341 заалт бүхий хугацаатай албан шаардлагыг 8 ААН-д хүргүүлж 4 ААН-д 9.5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

МХЕГ-аас 2018 оны 11 дүгээр сард Говь сүмбэр, Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий аймаг болон Нийслэлийн МХГ-ын байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч, байгаль орчны мэргэжилтнүүдэд "Уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны хохирол тооцох аргачлал" сэдэвт Зүүн бүсийн сургалтыг Сайншанд суманд зохион явуулсан байна.

Хууль, журмын заалт, түүний хэрэгжилтийн байдал, МХГ-ын шалгалтын дүн зэргээс үзэхэд уул уурхайн компани болон төр захиргаа, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын ажлын уялдаа сул, ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалж геологи, уул уурхай, байгаль орчныг хамгаалах тухай, хөдөлмөрийн тухай, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, усны тухай, хөрс хамгаалах, цөлжилтөөс хамгаалах тухай, газрын тухай, эрүүл ахуйн тухай хуулиудын холбогдох заалтууд зөрчигдөж байна.

В.2.3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг ихэнх компаниуд ирүүлээгүй байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-05 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 1.5-д "Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байна",

Мөн журмын 3.3-т "Төсөл хэрэгжүүлэгчээс тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймаг, нийслэлийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажиллуулан дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулах ба уг ажлын хэсэгт аймаг

нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно”,

Мөн журмын 5.5-д “Ашигт малтмалын орд ашиглаж буй төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ... оны жилийн мэдээ маягт БОХ-3-ын дагуу холбогдох мэдээллийг гаргаж, тухайн сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлэх ба уг маягтыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заавал хавсаргана” гэж заасан байна.

БОАЖГ-т ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 11 компани 2019 оны БОМТ-г хянуулсан, БОМТ-ний тайлан ирүүлж үнэлүүлж дүгнүүлсэн компани 2017 онд 16, 2018 онд 20 байна. 2019 онд 27 компани БОМТ-ний тайланг ирүүлсэн байна.

БОАЖГ-аас БОМТ-г хангалтгүй хэрэгжүүлсэн гэсэн үнэлгээг 2017 онд Айраг сумын нутагт манганы олборлолт хийж буй Алтраг ахас ХХК /24.7 оноо/, Мандах сумын нутагт Цагаан суварга зэс молибден профирын ордод үйл ажиллагаа явуулж буй Монголын алт ХХК /14.2 оноо/-д өгсөн байв.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ихэнх нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан гаргаж холбогдох газар хүргүүлээгүйгээс тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн эсэхийг нотлох боломжгүй байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нөхөн сэргээлт хийсэн талаар зөвхөн утсаар мэдэгддэг байна. БОАЖГ-т компаниудаас ирүүлсэн тайланд:

БОМТ-нд тусгагдсаны дагуу 2017 онд техникийн нөхөн сэргээлтийг Чингисийн хар алт ХХК 1.19 га, 2018 онд Бадрах энерги ХХК 4.08 га, УБТЗ-ын Чулуун завод 0,05 га газарт, биологийн нөхөн сэргээлтийг 2017 онд Чингисийн хар алт ХХК 1.09 га газарт хийжээ.

2019 онд 12 сумын нутагт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 10 компани 20.8 га талбайд, иргэд, нөхөрлөл 39.1 га талбайд, ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулдаг 5 компани 10.0 га талбайд, Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, сумын ЗДТГ-аас нөхөн сэргээлтийн дансанд байршуулсан хөрөнгөөр 19.1 га газарт, Салхин парк, Монгол шанхайн Линххуа олон улсын худалдаа гэсэн 2 байгууллага 6.6 га газарт, нийт 95.6 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.

Биологийн нөхөн сэргээлтийг 2019 онд Айраг сумын Говийн өнгө нөхөрлөл 2.5 га талбайд, Даланжаргалан суманд Эко хэлхээ ХХК 3.3 га талбайд тус тус хийсэн байна.

В.3 Хамтран ажиллах гэрээг дүгнээгүй, үр дүнг тооцоогүй байна.

В.3.1 Талууд гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-т хамтран ажиллах 2017 оны гэрээний хэрэгжилтийг компаниудаас ирүүлээгүй, 2018 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг 11 аж ахуйн нэгж ирүүлснээс 3 аж ахуйн нэгж нь ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй тул гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй байсан тухайгаа, нэг компани хамтран ажиллах гэрээг дуусгавар болгох хүсэлт ирүүлсэн байна.

Хамтран ажиллах гэрээнд:

- Засаг даргын эрх үүрэг хэсэгт “Ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрлэл явуулах хугацаанд компанид хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлж, хяналт тавина, шинэ ажлын байр нэмэгдүүлж буй ажил олгогчийг урамшуулан дэмжинэ, аймаг сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээлнэ”,
- Гэрээний хэрэгжилт хэсэгт “Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээг аймгийн болон компанийн цахим хуудсанд байршуулна, Хамтын ажиллагааны хороо нь гэрээний биелэлтийг жилд нэг удаа дүгнэх ба Засаг дарга тайланг аймгийн ИТХ-д танилцуулна”,
- Гэрээний хариуцлага хэсэгт “Гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлага гаргаж ажиллана, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ”,

Гэрээний дээрх заалтууд хэрэгжээгүй байна. Уул уурхайн компаниудын дийлэнх хувь нь үйл ажиллагаа явуулаагүй, олборлолт хийгээгүй, үйл ажиллагаа явуулсан компани гэрээний үүргийг хангалтгүй биелүүлсэн, гэрээний биелэлтийг талууд дүгнээгүй байна.

Хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүйгээс төлөвлөсөн ажлууд хангалтгүй хэрэгжиж, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтууд хангагдахгүйд хүрч байна.

В.3.2 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид сумын төсвийн орлогод хогны төлбөр төлж, байгууллагуудад хандив, тусламж үзүүлсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих" гэж нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын эрх үүрэгт заасан байна.

Даланжаргалан суманд ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 72 компанийн 33.3 хувь буюу 24 компанитай 2019 онд “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан байна. Сумын хогны хураамжийн дансанд 22 компаниас 32.7 сая төгрөгийн төлбөр хийгдсэн байна.

Мон ли да ХХК Даланжаргалан сумын багийн төвийн барилгад 4.0 сая төгрөг, баяр наадмын хандив 2.0 сая төгрөг, 6 малчны худгийн кольцо суулгаж засахад 3.0 сая төгрөг хандивласан, байгаль орчныг нөхөн сэргээх ажлын хүрээнд суманд 1000 ш суулгац өгсөн байна.

Айраг суманд ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 30 компанийн 63.3 хувь буюу 19 компанитай 2019 онд “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан байна. Эдгээрээс 11 компани хогны төлбөрт нийт 1.9 сая төгрөг төлсөн байна. Айраг сумын хогны төлбөрийн хэмжээ нэг сард 15.0 мянган төгрөг байгааг нэмэгдүүлж өөрчлөх шаардлагатай байна.

Айраг суман дахь уул уурхайн зөвшөөрөлтэй компаниудаас Эм си ти ХХК болон Бужгар орд ХХК чөлөөт бөхийн болон 100 буудалт даамны ДАШТ-нд оролцсон хүүхдүүдэд тус бүр 300.0-500.0 мянган төгрөг, шинээр баригдаж байгаа 36 айлын орон сууцны барилгын материал татахад Мин ли да ХХК 18.0 сая төгрөг, Бужгар орд

ХХК элс хайрга зөөхөд 5.0 сая төгрөг, Айвору ХХК ЗДТГ-т 3.4 сая төгрөгийн 2 компьютер хандивлаж тусламж дэмжлэг үзүүлсэн байна.

В.3.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс эд хөрөнгийн хохирол төлөх асуудал гараагүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс эд хөрөнгийн хохирол төлөх асуудал гараагүй байна.

Холбогдох байгууллагын санал:



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас: 7052 2533,
Факс: (976) 7052 2530, И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn,
Вэбсайт: dornogovi.gov.mn

2020.01.21 № 1/221

танай 01.10 -ны № 1-6/21 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ч.АРИНУАА ТАНАА

“Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт,
үр дүн” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн
төсөлд өгөх тайлбар, саналыг хавсралтаар
хүргүүлэв.

Хавсралт: 3 хуудастай.


Т.ЭНХТҮВШИН

44 6200076

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНД ӨГӨХ САНАЛ

Бүлэг-1.-ийн А.1.3 Даланжаргалан сумын Өндөр нэртэй 2534.48 га талбайд ашигт малтмалын хайгуулын XV-019370 тоот тусгай зөвшөөрлийг 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр АОГО ХХК-д олгосон.

Бүлэг-2.-ын Б.1.2: Уул уурхайн үйл ажиллагаа болон эзэн холбогдогчгүй эвдрэлд орсон газрын тооллогыг зохион байгуулж эврэлд өртсөн 450.4, талбай га талбайг бүртгэлжүүлсэн. Тайлант хугацаанд орон нутгийн төсөв болон хувийн хэвшлийн санал санаачилгаар 19,6 га талбайд биологийн, 167.47 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж нийт нөхөн сэргээх шаардлагатай газрын 41,6%-ийг нөхөн сэргээсэн.

Уул уурхайн тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байгаа компанидын ашиглалтын үйл ажиллагаа бүрэн явагдаж дуусаагүй тул тусгай зөвшөөрлийн талбайд нөхөн сэргээлт хийх хэмжээнд хүрсэн талбай байхгүй болно.

2019 онд Айраг, Алтанширээ Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт,Өргөн, Улаанбадрах,Мандах, Хатанбулаг, Сайхандулаан, Эрдэнэ гэсэн 11 суманд үйл ажиллагаа явуулдаг Эм Си Ти Ти Экочиглэл, Экилешия, Чингисийн хар алт, Голден говь констракшн материал, Эко хэлхээ Ачир, Билэгт баялаг, МАК, Бүтэн бүрмэл, Салхин парк, Зараяа холдинг, Монлаа Голден говь айбек, Монлаа, Маргац интернэшнл, Улиастай чулуу, Мандговь, Монгол Шанхайн Линхуа олон улсын худалдаа зэрэг 19 компани, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, эзэн холбогдогчгүй эвдрэлд орсон газруудыг иргэд болон бүлэг нөхөрлөлүүдтэй хамтран хэрэгжүүлж 75.3 га-д техникийн, 5.8 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн.

/Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилт бүрэн хангагдаагүй гэсэнтэй санал нийлэхгүй байна./

Бүлэг-2.-ын Б.2.1: Аймгийн хэмжээнд нийт 29 уул уурхайн компанийн бүтээгдэхүүн тээвэрлэлт хийх 1388,91 км замын маршрут тогтоогдсноос 205,2 км замыг сайжруулаад байна. */Бүртгэлийг хавсаргав./*

Үүнээс: 2019 онд Даланжаргалан, Айраг сумдын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 4 компанийн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт хийх 141,2 км замын маршрутыг тогтоосноос Даланжаргалан сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Аривжих энерги” ХХК-ийн “Аривжих далан” уурхайгаас “МАК” ХХК-ийн ашиглаж байсан 5.2 км сайжруулж, 9 уурхай 27 км замд засвар арчилгаа хийсэн.

Даланжаргалан сумын “Айраг Эксплорэйшн” ХХК-ийн уурхайгаас “Эко хэлхээ” ХХК-ийн баяжуулах үйлдвэр хүртэлх 38 км орон нутгийн авто замын чиглэл, Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Олон ихт баян” ХХК-д “Хутагт”-ын уурхайгаас Даланжаргалан сумын 25 дугаар зөрлөгийн ачилт буулгалтын талбай хүртэлх 22,7 км авто замын чиглэл, Дундговь аймгийн Баянжаргалан сумын “Хөх дэл” уурхайгаас Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Монголросцветмент” ХХК-ийн Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэр хүртэл жонш

тээвэрлэлт хийхэд 87 км авто замын чиглэлийг баталснаас 50 км авто замын шороон далангийн ажил хийгдсэн 2020 оноос хатуу хучилттай болгох ажил хийгдэнэ.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр болон шинээр барьж буй төмрийн хүдэр баяжуулах, кокс, ширмийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх зорилгоор Сайншанд-Баруун-Урт-Чойбалсан чиглэлийн хэвтээ тэнхлэгийн төмөр замын трасстай эхлэл болох 12 км төмөр замыг Алтанширээ сумын "Сайн Ус" хэмээх газарт "Монголиан Транс Ложистик" ХХК өөрийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан. Алтанширээ сумын нутаг дэвсгэрт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн 18,8 км төмөр зам, 16,8 км авто зам ашиглалтад орсон. Таван толгой-Зүүнбаян чиглэлийн 414,6 км төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах газар шорооны ажил 82 хувийн биелэлтэйгээр ажиллаж байна.

Дээрх төмөр замууд бүрэн ашиглалтад орноор уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтээс шалтгаалах сөрөг нөлөөлөл багасаж нөхцөл бүрдэнэ.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын байгууллагаас нийт 13 удаагийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж давхардсан тоогоор 139 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан, 19 акт, 73 албан шаардлага, 20 зөвлөмж, 7 дүгнэлт гарган хүргүүлж, 27 аж ахуйн нэгжид 95.5 сая төгрөгийн торгууль, 3 аж ахуйн нэгжид 141,8 сая төгрөгийн хохирол, нөхөн төлбөрийг ногдуулан, төлбөрийг хуулийн хугацаанд бүрэн барагдуулан ажилласан.

Уул уурхайн салбарт ашиглалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагууд санаачлан 2016 онд анх "Дорноговь их хөгжил сан"-г байгуулан орон нутгийн төрийн байгууллагаас үл хамааралтайгаар аймгийн нийгэм, дэд бүтцийн хөгжил, иргэдийн тогтвортой хөгжлийг дэмжиж нийгэмд чиглэсэн олон арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэн ажилласан.

2017 онд аймгийн Иргэдийн Хөгжлийн нэгдсэн төвийн барилга, Даланжаргалан сумын Олон овоо багийн гудамжны цамхагт гэрэлтүүлгийг 4 газар байршуулах тохижилтын ажилд 37.6 сая төгрөг, хүүхдийн тоглоомын иж бүрэн талбайг 49,5 сая.төгрөг, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгийн цэвэр ус, ариутгах татуургын шугамын их засварыг хийж гүйцэтгэсэн. Алтанширээ сумын төвийг гүний худагтай болгосон. Сайншанд сумын 4-р багийн ус түгээх байх, зорилтот 10 өрхийг гэртэй болгож амьдрах нөхцлийг сайжруулсан. Дэлгэрэх сумын соёлын төвийн хөгжим, тоног төхөөрөмжийн шинэчлэл, мал эмнэлгийн их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг тус тус хийж гүйцэтгэсэн.


30 сурагч, 3 багш, нийт 33 хүний баг бүрэлдэхүүнийг Япон Улсын Шизуоко мужид 7 хоног туршлага судлах, 32 сурагч, 8 багш нийт 40 хүний бүрэлдэхүүнтэй багийг ОХУ-ын Эрхүү хотод харилцан туршлага солилцох замын зардлыг тус сангаас бүрэн санхүүжүүлсэн. "Ирээдүйн манлайлагч-2017" тэтгэлэгт хөтөлбөрт 46 оюутныг хамруулан сургалтын төлбөрийг санхүүжүүлэн боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийсэн. Дэлхийн аварга шалгаруулах даамын тэмцээн, "Дорноговь цом-2017" холимог насны боксчдын аварга шалгаруулах олон улсын тэмцээн зэрэг нийгмийн салбарт чиглэсэн олон арга хэмжээг санхүүжүүлэн орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлсэн.

2018 онд Хамтран ажиллах гэрээний дагуу Сайншанд суманд гэр бүлийн талбайг "Цайрт минерал" ХХК-ийн 680,0 сая төгрөгөөр, 3*3 сагсан бөмбөгийн талбайг "Салхин парк" ХХК-ийн 35,0 сая төгрөгөөр, нийт орон сууцны засвар үйлчилгээнд "Зэс орд" ХХК-ийн 240,5 сая төгрөгөөр, Даланжаргалан суманд 75 хүүхдийн цэцэрлэг байгуулах ажлыг "Фриендшип ресурс" ХХК-ийн 892,0 сая төгрөгөөр, Олон-овоо багт сургуулийн спорт заалны барилгыг "Чингисийн Алт" ХХК-ийн 268,0 төгрөгөөр, Эрүүл мэндийн төвийн гадаа талбайн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг "Тэнүүн байгаль" ХХК-ийн 10,0 сая төгрөгөөр, Зүүн баян багт 50 хүүхдийн цэцэрлэгт хүрээлэнг "Доншен Монгол" ХХК-ийн 499,6 сая төгрөгөөр, "Рос энерго" ХХК, "Чандмань Өлзийт" ХХК нар Айраг сумын наамдын талбайг 161,2 сая төгрөгөөр, Алтанширээ сумын ЗДТГ болон ахуйн үйлчилгээний гадна болон дотор засварын ажлуудыг "Синотум Монголиа" ХХК-ийн 142,3 сая төгрөгөөр, Дэлгэрэх сумын Соёл спортын цогцолборыг -1,200,0 сая төгрөгөөр, Сайхандулаан сумын Эрүүл мэндийн төвийн засвар, Хатанбулаг сумын Соёлын төвийн их засварын ажлыг "Мон лаа" ХХК-ийн 30,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, 25 сурагч, 3 багш, нийт 28 хүний баг бүрэлдэхүүнийг Япон Улсын Шизуоко мужид туршлага судлах замын зардал, Эрдэнэ сумын дулаан бохир усны шугам сүлжээний ажилд санхүүгийн дэмжлэг, Хөвсгөл сумын төвийн хог хаягдлыг булшлах, шинээр хог хаягдал болон бохирын цэг байгуулах, Хатанбулаг сумыг бохир ус шингээх далан, шинэ хогийн цэгтэй болгож, Соёлын төвийн их засварын ажлыг "Мон лаа" ХХК-ийн 30,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийгмийн салбарт чиглэсэн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2019 онд Аймгийн цагдаагийн газрын барилгын өргөтгөл, засварын ажил, Музей сургалт судалгааны төвийн үзмэрийн танхимууд, бусал өрөөнүүдийн их засварын ажил, Сайншанд сумын 8-р цэцэрлэгийн барилгын сантехникийн засварын ажил, Сайншанд сумын түр хамгаалах байрны гадна, дотор тохижилтын ажил, Замын-Үүд сумын Хилийн цэргийн 108 дугаар ангийн Соёл спортын заалны барилгын ажил, Зүүн баян багийн Эрүүл мэндийн төвийн засвар, Өргөн сумын нутийн орон сууцны 4,5-р барын фасад засвар, Мандах сумын сумын хогийн машин, Хилийн цэргийн 0168-р ангийн төвл тусгай бэлтгэлийн болон цайны газрын зориулалтын барилгын ажил, Хатанбулаг сумын наадмын талбай барих, Ханги-Мандал хилийн боомтод бохир соруулах авто машин, Хөвсгөл суманд пургон авто машин, Даланжаргалан суманд фургон авто машин, хогийн машин, нийтийн орон сууцны гадна фасадын засвар, Сайхан дулаан сумын Жаргалант багийн төвийн хурлын заал, Дэлгэрэх сумын төвийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөв, хүүхдийн тоглоомын талбайг, хүүхдийн цэцэрлэгийн гадна тоглоомын талбай дэд бүтэц, нийгмийн салбарт чиглэсэн олон арга хэмжээг санхүүжүүлэн орон нутгийн хөгжилд томоохон дэмжлэгүүдийг 2016 оноос хойш үзүүлсэн нь уул уурхайн үр өгөөжийг ихээхэн нэмэгдүүлэн ажилласан гэж үзэж байна.

Тайлбар мэдээлэл гаргасан:


АЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн



Х.Отгонжаргал

Тайлбар мэдээллийг хянасан:

АЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга



Ч.Түвшинтөр



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайлшанд сум, 3 дугаар баг,
 Утас: (705) 2-39-98
 Бүх сайт: dornogovi@gazar.gov.mn

2020.01.14 № 57
 танай _____-ны № _____-т

┌ **ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ** ┐
 └ **ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ** ┘

"Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой санал байхгүй болно.

ГАЗРЫН УДИРДЛАГЫН
 ХЭЛТСИЙН ДАРГА  Н.ОЮУНГЭРЭЛ



44200010



ДОРНОГОВЬ АЙМАГ
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА

44125 Дорноговь аймаг, Айраг сум, Цагаандөрвөлж,
 Утас/факс: (02-524) 1-41-54
 Бүх сайт: zdrg@airag.do.gov.mn

2020.01.16 № 5/36
 танай 2020.01.16-ны № 16/22-т

┌ **ДОРНОГОВЬ АЙМГИЙН** ┐
 └ **ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР** ┘

Усны төлбөр дутуу төлөгдсөн нь баяжуулах үйлдвэрүүд энэ онд үйл ажиллагаа явуулаагүйгээс уул уурхайд ашиглах усны хэмжээ бага гарсан. Хайгуулын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч XV-013406 дугаартай Хэрлэнголийн үйлс ХХК нь Хойд хонгор нэртэй талбайд 9-р сард 500000, XV-015186 дугаартай Нэргүй толгой нэртэй Эм энд Би майнинг ХХК нь 6-р сард 1000000 төгрөг тус тус сумын нөхөн сэргээлэлтийн дансанд байршуулсан байна.

ОРЛОГЧ  Б.АМГАЛАНБААТАР



4472000041

D:disk jijig toot

Саналд өгсөн тайлбар:

Ирүүлсэн санал, баримт материалд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн санал:

1. Бүлэг “А”-ийн 1.3-т ирүүлсэн саналыг хүлээн авч дүнгийн хэсэгт өөрчлөлт оруулав.
2. Бүлэг “Б”-ийн 1.2-т ирүүлсэн саналд өгөх тайлбар: Аудитын тайлангийн дүнгийн хэсгийн В.2.3-т БОАЖГ-аас авсан мэдээлэлд үндэслэн уул уурхайн компаниудын биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийсэн тухай бичсэн болно.
3. Бүлэг “Б”-ийн 2.1-д ирүүлсэн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замыг сайжруулсан асуудлыг аудитын дүнгийн хэсэгт нэмж орууллаа. “Дорноговь их хөгжил сан”-гийн үйл ажиллагааг аудитаар авч үзээгүй болно.

Айраг сумын Засаг даргаас ирүүлсэн санал:

1. Бүлэг “В”-ийн 1.1-д ирүүлсэн саналыг хүлээн авч, дүнгийн хэсгээс “Эм энд Би майнинг ХХК /XV-015186/ 2019 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулаагүй” гэсэн хэсгийг хасав.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

Орон нутгийн саналыг харгалзахгүй тусгай зөвшөөрөл олгож байгаагаас сонгон шалгаруулахаар батлагдсан зарим талбайг соёлын өвд бүртгэгдсэн болон орон нутгийн тусгай хэрэгцээний газар нутагтай давхцуулан олгосон байна.

АМГТГ орон нутгийн саналыг харгалзахгүйгээр 2017-2019 онд нийт 67.9 мянган гектар талбайд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгожээ.

Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтын хүрээнд уул уурхайн компаниуд орон нутагт дэмжлэг, хандив тусламж үзүүлсэн, ажлын байр нэмэгдүүлж ажилласан байна.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 4-6 удаа сунгуулсан нь 3 удаа сунгуулна гэсэн хуулийн заалтыг зөрчиж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дийлэнх нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж холбогдох газраар хянуулж батлуулаагүй, байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулаагүй байна.

Аймаг, сумын холбогдох мэргэжилтэн, байцаагч нар ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллаагүй, чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн, хариуцлага сул байдлаас шалтгаалж орон нутгийн төсөвт орох орлого бүрэн төвлөрөөгүй байна.

Компаниуд БОНБУ, БОМТ-ний хуулбар хувь, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг аймаг, сумын Засаг даргад ирүүлээгүй байна.

Хамтын ажиллагааны хороог байгуулж ажиллаагүй, талуудын үйл ажиллагаанд тавих хяналт сул байдлаас шалтгаалж “Хамтран ажиллах гэрээний хэрэгжилт” бүрэн хангагдаагүй, гэрээг дүгнэж үр дүнг тооцоогүй байна.

Уул уурхайн компаниудын удирдлагын хариуцлага сул, дотоод хяналтгүй байдлаас шалтгаалж МХГ-ын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил арилаагүй, давтагдан гарч ашигт малтмалын тухай болон холбогдох хуулиудыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 1958.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс аудитын явцад 50.0 сая төгрөгийн усны төлбөр төлүүлж, холбогдох албан тушаалтанд зөвлөмж, нэг албан шаардлага хүргүүлээ.

Аудитын дүнд үндэслэн **“Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй байна”** гэж дүгнэлээ.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2018 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар”-ыг дахин нягталж хянуулах асуудлыг холбогдох газарт нь уламжилж өгөх тухай ҮАГ-т албан бичиг хүргүүлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Засаг дарга танаа:

1. БОНБУ, БОМТ-өө батлуулаагүй, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах талаар хуульд заасны дагуу арга хэмжээ авах
2. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргаж ашигт малтмалын тухай болон холбогдох хуулиудыг зөрчсөн ААНБ-д хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх, хуулийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авах
3. Айраг, Даланжаргалан сумдын засаг дарга нарт өгсөн зөвлөмжийг бусад сумдын Засаг дарга нарт хүргүүлж хэрэгжилтийг тооцож ажиллах
4. Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Амьтны тухай хуулиудыг зөрчиж олгосон талбайнуудыг холбогдох газарт хандан сонгон шалгаруулалтаас чөлөөлүүлэх.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст:

1. Уул уурхайн компаниудаас орон нутгийн төсөвт оруулах орлогыг нэр төрлөөр бүрэн тооцож төлөвлөх, төсөвт төвлөрүүлэх, өр төлбөрийг барагдуулах

Айраг, Даланжаргалан сумын Засаг дарга нарт:

1. Сумын байгаль орчны мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримтлан, хариуцлагажуулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах
2. Хамтын ажиллагааны хороог байгуулж талуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулах, хамтран ажиллах гэрээг дүгнэж, үр дүнг тооцож байх
3. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан эсэхэд тавих хяналтаа сайжруулах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. АРИУНАА

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор

Ц.Лүндэгмаа

Аудитор

П.Энхбаяр

ХЯНАСАН:

Аудитын менежерийн үүргийг

орлон гүйцэтгэгч

Э.Энхцэцэг



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/05


Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.2, 19 дүгээр 19.3.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 тоот тушаал, 2016 оны А/146 тоот тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитын тайлан, 01/01 ДГА-2019/18/НА тоот албан шаардлагыг тус тус баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлэхийг Аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Айраг, Даланжаргалан сумын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, Айраг, Даланжаргалан сумын Засаг дарга, БОАЖГ, ГХБХБГ-ын дарга нарт хүргүүлсүгэй.
4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Энхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА